

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
АРВАН ХОЁРДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН
/2019.11.26-2019.12.10/

2019 оны 12 дугаар сарын 11

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд:

Виз олголтын талаар:

1.1 Тайлант хугацаанд “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан БНХАУ-ын нийт 10 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- A / single -entry/-6
- HG /single-re-entry/-4

Нийт 10 гадаадын иргэнд виз олгож, тэмдэгтийн хураамжийн 1.080.000 /нэг сая наян мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын нийт 879 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:409

Гарах чиглэлд:470

Гашуунсухайт боомт

- Орох чиглэл -278
- Гарах чиглэл-334

Шивээхүрэн боомт

- Орох чиглэл-131
- Гарах чиглэл-136

1.2 Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 2 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 4 иргэний хасалт хийж ажилласан байна.

1.3 ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 42 иргэнийг бүртгэж, 40 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

1.4 Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус

үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 4 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан.

1.5 Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн болон албадан гаргагдсан БНХАУ-ын 3 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

1.6 Гадаад иргэдийн хяналт шалгалтын талаар:

Тайлант хугацаанд 1 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг мэдээллийн дагуу зохион байгуулж, шалгалтад 1 аж ахуйн нэгж, байгууллагын 4 гадаадын иргэн хамрагдсан байна. Энэ үеэр эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 2 иргэнийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан болно.

1.7 Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 2 иргэнд 200.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт нийт 200000 төгрөгийг төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан.

1.8 Албадан гаргасан талаар:

Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасныг үндэслэн нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 2 иргэнийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 37 дугаар зүйлийн 37.1.7, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам”-ын 3.7 дугаар зүйл, байгууллагын даргын энэ оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/462 дугаар тушаалыг үндэслэн Монгол Улсад гурван жилийн хугацаанд дахин орж ирэх эрхийг хасч, албадан гаргасан болно.

1.9 Виз хүчингүй болгосон талаар:

Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Виз олгох журам”-ын 5.2-т заасны дагуу БНХАУ-ын 2 иргэний визийг хүчингүй болгосон.

Байгууллагын даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын хүрээнд:

Тайлант хугацаанд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 2 иргэнийг торгож, хасалтыг хугацаанд нь хийж хилээр гаргасан.

Өмнөд бүс дэх газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх заавар батлах тухай” тушаалын дагуу харьяа нутаг дэвсгэрт бүртгэлтэй гадаад иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажилласан болно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Хүний нөөцийн програмд 20 албан хаагчийн цалин, төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэв, ур чадварын нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан. Мөн тус газрын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гарган энэ оны 12 дугаар сарын 06-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан.

Өмнөд бүс дэх газрын албаны байрны шав тавих ёслолыг энэ оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулан ажиллалаа. Шав тавих ёслолын ажиллагаанд

Гадаадын иргэн, харьяатын газрын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Ч.Тулгацоодол, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Дотоодыг хамгаалах тэнхимийн орлогч дарга Баян-Эрдэнэ, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ван Хай Фөн, барилгын ажил гүйцэтгэх компанийн захирал Сайшаалт, инженер техникийн ажилчид, оролцлоо.

2.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-0
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-3/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-12/
- Явуулсан бичиг /албан тоот-6/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-6
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 12 дугаар сард нийт 20 албан хаагчийн урьдчлгаа цалинд 5,100,000 төгрөгийг олгож, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,340,900 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 522,000 төгрөг, урсгал засварын зардалд 230,000 төгрөг, томилолтын зардалд 414,000 төгрөг, зочин төлөөлөгчийн зардалд 2,966,000 төгрөг, шуудан холбооны зардалд 25,415.50 төгрөг, тусламжид 1,015,225,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2019 оны 11 дүгээр сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

Газрын даргын 2019 оны А/13 дугаар тушаалын дагуу бүсийн газрын 2019 оны эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулах комисыг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан тооллогыг хийж гүйцэтгэн дүнг нэгтгэн ажиллаж байна.

2.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган, бүсийн хэмжээнд гарсан 1 эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан.

Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын цахим хуудсанд тус газрын 2019 оны 12 дугаар сарын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, тайлан, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажилласан байна.

2.4. Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр зөвлөмжийн талаар:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тус боомтын нүүрс тээврийн жолооч нарын хурууны хээний шалгалтын кабинүүд болон сендвичэн дээврүүдийг нурааж, цэвэрлэсэн.

Тус боомтыг шинээр барих, хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалт, цогцолборын өргөтгөлийн ажил 2020 оны II улирал хүртэл түр хойшлогдож, одоогийн байдлаар боомтын албан хаагчдын байрны хажуу талд боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын БНХАУ-ын ажилчин байрлах сендвичин түр байрны ажил хийгдэж байгаа бөгөөд боомтын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР